



**АУДИТЫН КОД: САГ-2018/17/СТА-ТЕЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Ахлах аудитор Г.Жавхлан

Утас: 261628 Цахим хаяг: [javkhlang@audit.gov.mn](mailto:javkhlang@audit.gov.mn)

Аудитор Ц.Цэрэнхүү

Утас: 261628 Цахим хаяг: [Tserenkhuuts@audit.gov.mn](mailto:Tserenkhuuts@audit.gov.mn)



**АГУУЛГА**

1	АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН.....	2
2	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ.....	5
3	Аудитын тайлан.....	6
3.1	Оршил.....	7
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	7
3.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	8
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
3.5	Дотоод аудит.....	9
3.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
3.7	Шилэн дансны мэдээлэл.....	10
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	11
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	11
3.9.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлууд.....	11
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлууд.....	11
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	12
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд.....	12
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	12
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	13
3.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
4	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	14
4.1	Зардлын талаар.....	15
4.2	хандивын талаар.....	16
4.3	Дотоод хяналтын талаар.....	17
4.4	Дотоод хяналтын талаар.....	18
5	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	19
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	19
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	20
5.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	21
5.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	22
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	27

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.01.25 № 1035  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
ӨЛЗИЙСАЙХАНЫ ЭНХТҮВШИН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2018\0425SAG25.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2018\0425SAG25.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### 3.1 ОРШИЛ

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Шадар сайд Өлзийсайханы Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд төсвийн зардлыг нэр төрлөөр нь хэтрүүлэхгүй байх, иргэд, байгууллагаас өгсөн хандивыг холбогдох журмаар зохицуулж байх, дотоод хяналтыг сайжруулах талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### 3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /цаашид УСНББОУС гэх/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 10-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.



Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ЗГ-2/171 дүгээр албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

### 3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Шадар сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар гамшиг болон аюул, орчны ноцтой бохирдолтоос сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах;
- Стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- Шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- Салбарын мэргэжлийн хяналтын асуудлыг зохион байгуулах;

Шадар сайдын дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Шадар сайд тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Шадар сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 390 арга хэмжээ төлөвлөснөөс 96.3 хувийн биелэлттэй байна.

Төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар товчоолов. Тухайлбал,


- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах үйл ажиллагааны арга хэмжээний 4 зорилтын хүрээнд 203 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 92.8 хувь
- Салбарын мэргэжлийн хяналтын асуудлыг зохион байгуулах арга хэмжээний 2 зорилтын хүрээнд 84 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 95 хувь
- Стандартчилал, хэмжил зүйн асуудлыг зохион байгуулах арга хэмжээний 7 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 97.7 хувь
- Шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг зохион байгуулах арга хэмжээний 7 зорилтын хүрээнд 90 арга хэмжээг төлөвлөж, 100 хувиар тус тус хэрэгжүүлсэн байна.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

### 3.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний



алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад харьяа агентлаг, байгууллага тус бүр өөрийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг шууд гүйцэтгэлээ.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамжийг ашиглажээ.

### 3.5 Дотоод аудит


Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод аудитыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Хүснэгт 1 Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН	
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	60	
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	60	
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	52	
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо	30
		Дүн (сая.төг)	225.4
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо	22
		Дүн (сая.төг)	197.4
6	Тоо	8	



Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Дүн (сая.төг)	28.0
---	---------------	------

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагууд тайлант онд нийт 52 хяналт шалгалт хийж, 225.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 197.4 сая төгрөгийн зөрчилд 22 зөвлөмж, 28.0 сая төгрөгийн 8 албан шаардлага, төлбөрийн акт тогтоосон байна.

Харин Засгийн газрын Хэрэг эрхлэх газар/цаашид ЗГХЭГ гэх/-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр 2017-2019 оны төлөвлөгөөндөө тусгасан боловч тайлант онд нэг ч байгууллагад дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Шадар сайдын төсвийн багцад 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 116,868.4 сая төгрөг баталж, үүнээс урсгал зардалд 93,910.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 19,526.4 сая төгрөг, гадаад зээл, тусламжаас санхүүжих зардалд 3,431.6 сая төгрөгийг тус тус баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 94.2 хувь буюу 110,107.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, үүнээс урсгал зардалд 92,057.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,853.2 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 18,049.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1,476.5 сая төгрөгөөр тус тус хэмнэжээ.


Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд батлагдсан нийт төсөвт зардлыг нийт болон бүлгийн дүнгээр хэтрүүлээгүй байна.

### 3.7 Шилэн дансны мэдээлэл

Шадар сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Харьяа агентлагууд өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломжийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбартай хамт сар бүр;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг тухай бүрт;
- Байгууллагын батлагдсан төсөв;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр;
- Худалдан авах ажиллагааны тайлан;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах зорилго бүхий зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээллийг тухай бүр;





Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудтай холбоотой зөрчил, дутагдал илрээгүй байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

### 3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

### 3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

#### 3.9.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлууд

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 6,990.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 2,016.5 сая төгрөгийн материаллаг бус алдааг залруулж, 114.8 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 30 төлбөрийн акт тогтоож, 1,244.9 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага өгч, 3,614.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 112 зөвлөмж хүргүүллээ.

**Шийдвэрлэсэн нь:** Дотоод хяналтыг сайжруулж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.


Дотоод аудитын талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулагдсан ЗГХЭГ-ын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газраас Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний нэг ч байгууллагыг дотоод аудитад хамруулаагүй байгаа нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж, түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** “Дотоод аудитын дүрэм”-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

#### 3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлууд

Төсвийн гүйцэтгэлийн талаар:



Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 116,868.4 сая төгрөг батлагдсанаас 110,107.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлыг бүлгийн дүнгээр хэтрүүлээгүй боловч гэрэл, цахилгааны зардлыг 9.4 сая, шуудан холбоо, интернетийн төлбөрийг 4.0 сая, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн зүйлс авах зардлыг 2.3 сая, эм бэлдмэл авах зардлыг 4.0 сая, урсгал засварын зардлыг 91.6 сая төгрөгөөр, нийт 5 зүйлийн зардлыг 111.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

Хандив тусламжийн талаар:

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газар /цаашид ОБЕГ гэх/-ын нэмэлт санхүүжилтийн дансанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 1,403.2 сая төгрөгийн хандив төвлөрснөөс ОБЕГ-ын даргын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/171 дугаар тушаалаар гамшиг осол, ой хээрийн түймэрт ажилласан албан хаагчдын сэргээн засах эмчилгээнд 20.4 сая, тээврийн зардал, үйлчилгээнд 14.2 сая, хандив өргөсөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нэрсийн жагсаалтыг сонинд нийтлэхэд 7.5 сая, нийт 42.1 сая төгрөг зарцуулсан нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөв.

### 3.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

#### 1. Авлагын талаар:

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 6,919.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа ба энэ нь өнгөрсөн оноос 2,852 сая төгрөгөөр нэмэгдсэний дотор ОБЕГ-ын нөөцийн бүрдүүлэлт, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хандив, төслийн харилцах дансны үлдэгдлийг Сангийн яаманд татан төвлөрүүлсэнтэй холбоотой 2,104.9 сая төгрөгийн авлага, байна.

#### 2. Өглөгийн талаар:

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт, 3,346.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл тайлагнагдсаны 2,911.9 сая төгрөгийн өглөг нь 2015-2017 онд цэргийн тэтгэвэрт гарсан 100 гаруй албан хаагчдад олгох тэтгэмжийн өглөг байна.

### 3.11 ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас төвлөрүүлсэн хандивын зарцуулалт.
- Авлага, өглөгийн дансны барагдуулалт.
- 

### 3.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ



Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэж, баримтжуулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 6,990.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 2,016.5 сая төгрөгийн материаллаг бус алдааг залруулж, 114.8 сая төгрөгийн зөрчлийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 30 төлбөрийн акт тогтоож, 1,244.9 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага өгч, 3,614.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 112 зөвлөмж хүргүүлээ.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудаас 6 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг санал дүгнэлт өгсөн байна.

### 3.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 78.3 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Х/711 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

### 3.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитын материаллаг байдлын түвшинг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 156,286.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 3,125.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

### 3.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



#### 4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

---

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүний дагуух бүртгэлийг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шадар сайдын ажлын албаны болон санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



#### 4.1 ЗАРДЛЫН ТАЛААР

#### Тэргүүлэх ач холбогдол №1

##### ҮАГ-ын ажиглалт:

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 116,868.4 сая төгрөг батлагдсанаас 110,107.1 сая төгрөгийн гүйцэтгэл гарч зардлыг бүлгийн дүнгээр төсөв хэтрүүлээгүй боловч гэрэл цахилгааны зардлыг 9.4 сая, шуудан холбоо, интернетийн зардлыг 4.0 сая, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн зүйлс авах зардлыг 2.3 сая, эм бэлдмэл авах зардлыг 4.0 сая, урсгал зардлыг 91.6 сая төгрөгөөр, нийт 5 зүйлийн зардлыг 111.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

##### Эрсдэлүүд:

Төсөв хэтрэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомж зөрчигдөх.

##### ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

##### Төсвийн захирагчийн хариу:

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

**4.2 ХАНДИВЫН ТАЛААР**

**Тэргүүлэх ач холбогдол №2**

**ҮАГ-ын ажиглалт:**

Тайлант онд Онцгой байдлын ерөнхий газрын нэмэлт санхүүжилтийн дансанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 1,403.2 сая төгрөгийн хандив төвлөрсөнөөс ОБЕГ-ын даргын 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/171 дугаар тушаалаар гамшиг осол, ой хээрийн түймэрт ажиллассан албан хаагчдын сэргээн засах эмчилгээнд 20.4 сая, тээврийн зардал, үйлчилгээнд 14.2 сая, хандив өргөсөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нэрсийн жагсаалтыг сонинд нийтлэхэд 7.5 сая, нийт 42.1 сая төгрөг зарцуулсан нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг Засгийн газраас баталсан журмын дагуу зохицуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд:**

Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн холбогдох заалт зөрчигдөх, хөрөнгө үрэгдэх, хууль тогтоомж зөрчигдөх.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

**4.3 Дотоод хяналтын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**ҮАГ-ын ажиглалт:**

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитын дүнгээр нийт 6,990.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,016.5 сая төгрөгийн материаллаг бус алдааг санхүүгийн тайланд залруулж, 114.8 сая төгрөгийн 30 төлбөрийн акт, 1,244.9 сая төгрөгийн 32 албан шаардлага тогтоож, 3,614.1 сая төгрөгийн 112 зөвлөмж өгөгдсөн байна.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Дотоод хяналтыг сайжруулж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд:**

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах, дотоод хяналт сулрах.

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

**4.4 Дотоод хяналтын талаар**

**Тэргүүлэх ач холбогдол №4**

**ҮАГ-ын ажиглалт:**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор байгуулагдсан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний нэг ч байгууллагыг дотоод аудитад хамруулаагүй байгаа нь МУЗГ-ын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж, түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина” гэж заасантай нийцэхгүй байна.

**ҮАГ-ын зөвлөмж:**

Дотоод аудитын дүрэм”-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Эрсдэлүүд:**

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах, дотоод хяналт сулрах.

**Төсвийн захирагчийн хариу:**

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**



## 5 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 5.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	99,241,735.6	108,312,388.5
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	273,215.0	1,382,205.7
<b>АВЛАГА</b>	4,067,785.8	6,953,251.0
<b>УРЬДЧИЛГАА</b>	193,410.2	219,896.5
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,649,636.8	28,930,266.6
<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	65,057,687.9	70,301,769.6
<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	0.0	524,999.1
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	181,573,746.1	181,345,592.4
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	181,573,746.1	181,345,592.4
<b>Биет хөрөнгө</b>	181,217,402.9	179,172,600.7
<b>Биет бус хөрөнгө</b>	356,343.2	2,172,991.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	280,815,481.7	289,657,980.9
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	6,655,313.8	4,537,305.9
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	6,655,313.8	3,373,887.1
<b>Өглөг</b>	6,077,799.6	3,225,773.0
<b>Урьдчилж орсон орлого</b>	577,514.1	148,114.1
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.0	1,163,418.9
<b>Урт хугацаат зээл</b>	0.0	1,163,418.9
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	274,160,168.0	285,120,675.0
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	274,160,168.0	285,120,675.0
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	99,112,220.0	91,803,751.7
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	156,197,734.2	175,646,151.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,850,213.8	17,670,771.7
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	280,815,481.7	289,657,980.9



## 5.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	160,205,979.3	160,516,803.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,977,029.8	33,491,898.9
Нийтлэг татварын бус орлого	27,105,229.9	31,529,082.9
Тусламжийн орлого	13,871,799.9	1,962,816.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	119,228,949.4	127,024,904.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	141,360,648.1	147,904,786.9
УРСГАЛ ЗАРДАЛ	125,042,583.9	124,500,416.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,348,071.9	108,735,526.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,265,455.3	64,220,467.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,820,356.1	3,962,466.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,473,437.7	4,944,980.4
Хангамж, бараа материалын зардал	3,505,456.5	4,743,773.6
Нормативт зардал	4,194,711.2	3,239,241.1
Эд хогшил, урсгал засварын зардал	2,201,149.1	1,823,647.8
Томилолт, зочны зардал	1,248,891.7	710,975.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,748,789.0	2,091,240.7
Бараа үйлчилгээний бусад зардал	18,889,825.3	22,998,733.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,694,512.0	15,764,889.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,318,064.2	23,404,370.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	18,845,331.1	12,612,016.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	26,243.0	554,703.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,279,533.9	911,295.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	17,592,040.2	12,255,425.0



### 5.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	232,388,119.8	0.0	232,388,119.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	24,182,171.6	0.0	24,182,171.6
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	256,570,291.5	0.0	256,570,291.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,163.7	0.0	-2,163.7
<b>Тайлант үеийн үр дүн</b>	17,592,040.2	0.0	17,592,040.2
<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	274,160,168.0	0.0	274,160,168.0
<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	274,160,168.0	0.0	274,160,168.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-622,130.1	0.0	-622,130.1
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	273,538,037.9	0.0	273,538,037.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-672,787.9	0.0	-672,787.9
<b>Тайлант үеийн үр дүн</b>	12,255,425.0	0.0	12,255,425.0
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	285,120,675.0	0.0	285,120,675.0

#### 5.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	147,971,063.6	142,173,637.4
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	30,642,212.9	15,237,610.4
Нийтлэг татварын бус орлого	21,509,510.3	13,730,453.6
Хөрөнгийн орлого	0.0	0.0
Тусламжийн орлого	9,132,702.6	1,507,156.8
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	117,328,850.8	126,936,027.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	115,319,797.7	122,556,200.5
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	115,319,797.7	122,556,200.5
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	97,527,515.1	101,907,593.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,383,426.1	64,116,396.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,813,054.3	3,946,632.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,721,920.7	5,037,139.5
Хангамж, бараа материалын зардал	3,285,748.8	3,165,879.3
Нормативт зардал	3,932,834.2	4,183,022.4
Эд хогшил, урсгал засварын зардал	1,736,927.7	1,348,570.0
Томилолт, зочны зардал	1,463,835.5	670,410.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,142,511.3	3,128,414.5
Бараа үйлчилгээний бусад зардал	11,047,256.4	16,311,128.3
ТАТААС	978.0	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,791,304.6	20,648,607.5
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	32,651,266.0	19,617,436.9
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	32,514,915.5	18,498,886.3
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	32,514,915.5	18,498,886.3
Дотоод эх үүсвэрээр	32,514,915.5	18,498,886.3
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-32,514,915.5	-18,498,886.3
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	0.0	-9,559.9
Бусад эх үүсвэр	0.0	24,250.9
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	0.0	33,810.8
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	136,350.4	1,108,990.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	136,864.5	273,215.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	273,215.0	1,382,205.7

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

### 5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,868,432.0	110,107,284.7	6,761,147.3	94.2
УРСГАЛ ЗАРДАЛ	96,930,040.1	92,057,340.5	4,872,699.6	94.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,128,245.9	85,541,838.9	4,586,407.0	94.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	65,609,454.7	63,954,635.4	1,654,819.3	97.4
Үндсэн цалин	48,159,765.4	47,237,514.2	922,251.2	98.1
Нэмэгдэл	13,024,330.5	12,482,179.7	542,150.8	95.8
Унаа хоолны хөнгөлөлт	1,947,578.7	1,916,194.2	31,384.5	98.3
Урамшуулал	8,331.5	8,331.5	0.0	100.0
Гэрээт ажлын хөлс	2,469,448.6	2,310,415.8	159,032.8	93.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,518,015.2	3,924,542.6	593,472.6	86.8
Тэтгэврийн даатгал	2,444,668.2	2,960,227.5	-515,559.3	121.1
Тэтгэмжийн даатгал	357,996.7	237,646.0	120,350.7	66.3
ҮОМШӨ-ний даатгал	291,486.6	193,543.5	97,943.1	66.4
Ажилгүйдлийн даатгал	78,510.5	48,319.3	30,191.2	61.5
Эрүүл мэндийн даатгал	1,345,353.2	484,806.3	860,546.9	36.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,215,747.7	4,953,853.9	261,893.8	94.9
Гэрэл, цахилгаан	958,489.2	967,874.5	-9,385.3	100.9
Түлш, халаалт	2,821,537.1	2,749,301.0	72,236.1	97.4
Цэвэр, бохир ус	315,145.3	277,279.1	37,866.2	98.9
Байрны түрээс	1,120,576.1	959,399.3	161,176.8	85.6
Хангамж, бараа материалын зардал	3,035,895.5	2,900,986.4	134,909.1	95.5
Бичиг хэрэг	311,693.6	291,621.8	20,071.8	93.5
Тээвэр, шатахуун	2,065,531.7	1,947,373.6	118,158.1	94.2



Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	460,779.4	464,837.3	-4,057.9	100.8
Ном, хэвлэл	3,666.8	3,507.2	159.6	95.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,343.4	17,450.0	2,893.4	85.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	173,880.6	176,196.5	-2,315.9	101.3
Нормативт зардал	3,965,097.4	3,962,213.7	2,883.7	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	539,021.0	543,031.9	-4,010.9	100.7
Хоол, хүнс	604,622.0	604,626.9	-4.9	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,821,454.4	2,814,554.9	6,899.5	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	961,811.9	962,000.3	-188.4	100.0
Багаж, техник, хэрэгсэл	308,160.9	253,308.6	54,852.3	82.2
Тавилга	3,300.0	3,300.0	0.0	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	59,383.3	22,549.9	36,833.4	37.9
Урсгал засвар	590,967.7	682,841.9	-91,874.2	115.5
Томилолт, зочны зардал	555,124.7	540,496.4	14,628.3	97.3
Гадаад албан томилолт	0.0	11,194.7	-11,194.7	0.0
Дотоод албан томилолт	553,966.3	528,247.8	25,718.5	95.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,158.4	1,054.0	104.4	90.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,115,978.1	2,947,460.0	168,518.1	94.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,881,745.3	1,743,364.3	138,381.0	92.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	41,918.6	35,808.2	6,110.4	85.4
Даатгалын үйлчилгээ	737,877.5	729,699.8	8,177.7	98.8
Тээврийн хэрэгслийн татвар	63,407.5	55,227.8	8,179.7	87.1
Тээврийн хэрэгслийн оношлогоо	16,528.9	16,117.1	411.8	97.5

01

ТӨСВИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	115,746.4	114,657.0	1,089.4	99.0
Газрын төлбөр	93,881.8	89,337.1	4,544.7	95.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	166.7	153.0	13.8	91.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	164,705.4	163,095.7	1,609.7	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,151,120.7	1,395,650.1	1,755,470.6	44.2
Бараа үйлчилгээний бусад зардал	2,477,239.4	735,326.6	1,741,912.8	29.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	673,881.3	660,323.5	13,557.8	97.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,801,794.2	6,515,501.6	286,292.6	95.7
Засгийн газрын урсгал шилжүүлэг	218,782.7	217,359.3	1,423.4	99.5
Засгийн газрын гадаад шилжүүлэг	218,782.7	217,359.3	1,423.4	99.3
Бусад урсгал шилжүүлэг	6,583,011.5	6,298,142.3	284,869.2	95.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,310.5	484,973.9	15,336.6	96.9
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500.0	4,500.0	0.0	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,035,051.0	3,909,472.5	125,578.5	96.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,043,150.0	1,899,195.9	143,954.1	92.9
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,938,391.9</b>	<b>18,049,944.2</b>	<b>1,888,447.7</b>	<b>90.5</b>
Барилга байгууламж	6,322,092.0	6,187,519.5	134,572.5	97.8
Тоног төхөөрөмж	806,598.9	974,372.0	-167,773.1	120.8
Бусад хөрөнгө	338,433.8	339,116.2	-682.4	100.2
Стратегийн нөөц хөрөнгө	12,471,267.2	10,548,936.5	1,922,330.7	84.5
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>116,868,432.0</b>	<b>111,903,976.3</b>	<b>4,964,455.7</b>	<b>95.7</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	108,647,695.9	104,856,530.0	3,791,165.9	96.5
Улсын төсвөөс санхүүжих	108,647,695.9	104,856,530.0	3,791,165.9	96.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,139,844.2	5,588,583.9	551,260.3	91.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,789,060.3	4,328,286.5	460,773.8	90.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	96,878.5	-96,878.5	0.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,350,783.9	1,163,418.9	187,365.0	86.1
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	2,080,891.9	1,458,862.4	622,029.5	70.1
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	2,080,891.9	1,458,862.4	622,029.5	70.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	11,142.8	-11,142.8	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	1,117,833.6	-1,117,833.6	0.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13,709.00	13,202.00	507.00	96.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	91.0	91.0	0.0	100.0
Төсвийн байгууллага	91.0	91.0	0.0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	6,809.0	6,678.0	131.0	98.0
Удирдах ажилтан	121.0	122.0	-1.0	100.8
Гүйцэтгэх ажилтан	5,538.0	5,381.0	157.0	97.1
Үйлчлэх ажилтан	728.0	748.0	-20.0	102.7
Гэрээт ажилтан	422.0	428.0	-5.0	101.1
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6,809.0	6,433.0	375.0	94.4

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ



Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын  
2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,922.0	1,878.0	44.0	97.7
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3,730.0	3,415.0	315.0	91.5
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	726.0	725.0	1.0	99.8
Гэрээт ажилтан	429.0	415.0	14.0	96.7
Улс төрийн албан хаагч (УТ)	2.0	0.0	2.0	0.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**